MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Канадын Жендэрийн дүн шинжилгээ+

Агуулга

- Хүйс vs. жендэр
- “Нэмэх тэмдэг”-ний утга
- Заавал биелүүлэх хариуцлага
- Хэрэгжилтийн тогтолцоо

Хүйс vs. жендэр

- Хүйс ба жендэрийн тодорхойлолтыг хооронд хольж солин буруугаар ашиглах нь олонтоо тохиолддог.
- Төрөөс санаачилж буй бодлого хөтөлбөрийн үр нөлөө, өгөөжийг тодорхойлохыг хүсч байвал эдгээрийг сайтар ялгаж салгаж ойлгон, нухацтай авч үзэх хэрэгтэй.
- Та зөвхөн аль нэг нь л нөлөөлөхүйц хүчин зүйл болно гэж тооцож болох ч заримдаа бодсоноос эсрэгээрээ эргэж болно.

Хүйс ба жендэр, “нэмэх тэмдэг”-ний утга

- Бүх хүнийг эрэгтэй, эмэгтэй эсвэл эршүүд, эмэгтэйлэг гэж хүйс, жендэрийнх нь хувьд ангилан хоёр цул ойлголтоор тодорхойлох боломжгүй. Хүйсийн баримжааны талаарх асуудлыг Канадад төдийгүй дэлхий даяар чухлаар авч үзэж, олон яриа хэлэлцүүлэг өрнөж байна. Хүйс, жендэр болоод эдгээр нэршлийг хэзээ, хэрхэн ашиглах талаар бидний ойлголт ч хувиран өөрчлөгдөж байна.

“Нэмэх тэмдэг”-ний ерөнхий утга

- Жендэрийн дүн шинжилгээ$^{+}$ нь зөвхөн жендэрийн тухай биш бөгөөд нийгмийн бүлгүүд ч гэсэн нэг хэвэнд цутгасан мэт адилхан байдаггүй.
- Бидний хэн бэ гэдгийг тодорхойлдог харилцан хамаарал бүхий олон хүчин зүйл буюу хүн ам, нийгмийн үзүүлэлт бидэнд байдаг.
- Энд дурдагдсан “нэмэх тэмдэг” нь ЖДШ нь үргэлж хүйс, жендэрээс халисан хүн ам, нийгмийн үзүүлэлтүүдийг авч үздэгийг илтгэж буй хэрэгюм. Хүйс, жендэр нь яс үндэс, гарал угсаа, шашин шүтлэг, нас, сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг бусад хүчин зүйлээс хэрхэн хамаарч, харилцан нөлөөлж байгааг анхаарч үздэг байна.

Заавал биелүүлэх хариуцлага

- Холбооны бүх албан хаагч төрийн бодлого, хөтөлбөр боловсруулахдаа өөрсдөөсөө наад захын зарим асуултыг асууж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өөр хүйсийн хүмүүс зэрэг нийгмийн олон бүлгийн талаарх өөрийн өрөөсгөл үзэл таамаглалыг сөрөн зогсох замаар уг дүн шинжилгээг ажилдаа нэвтрүүлэх үүрэгтэй. ЖДШ$^{+}$-г ажилдаа системтэйгээр ашиглах замаар Холбооны Засгийн газрын албан хаагчид асуудлыг олон өнцгөөс нь харж, ажлаа сайжруулах боломж бүрджээ.

Хэрэгжилтийн тогтолцоо

- Цахим сургалт;
- Зөвлөн туслах;
- Бодлого;
- Энэ чиглэлийн ажил, түүний үр дүнг бүртгэж тайлагнах хариуцлага хүлээлгэх зэрэг багтана.

Практикт хэрэгжүүлэх

- Төрийн албан хаагчид тэдний бодлого, үйл ажиллагаа хүн бүрт тэгш үйлчилдэг, анхаарч үзвэл зохих жендэрийн ба олон талт байдлын асуудал гарахгүй гэж тооцох нь олонтоо.
- ЖДШ$^{+}$ нь тэдэнд өрөөсгөл байж мэдэх таамаглалыг анзаарч, цааш харах, хүмүүсийн амьдралын бодит байдлыг олж таних, тэдний хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх арга замыг олоход нь тусалдаг.

Хэрэглэх асуултууд

- Таны шийдэхээр ажиллаж буй асуудал жендэрийн хувьд саармаг гэж та бодож байна уу? Эсвэл соёлын хувьд саармаг уу? Чадвар саармаг уу? Энэ нь зөвхөн миний өөрийн туршлагад тулгуурласан байна уу?
- Миний таамаглал, хувийн бодол зохих асуулт асууж, өөрийн туршлагаас гадуурх хариултыг сонсож, хүлээн авахад саад болж байх магадлалтай юу?
- Миний өөрийн, манай байгууллагын, эргэн тойрны хүмүүсийн, нийгмийн хандлага, хэм хэмжээ нь боловсруулж, санал болгож буй бодлогын хувилбарын хүрээг хэрхэн хязгаарлаж болзошгүй вэ?

Хэрэгжилт

- Бодлогын баримт бичиг, үзэл баримтлалд ЖДШ$^{+}$ хийх үүрэг хариуцлагыг тодорхой зааж, хэрэгжүүлэх чиг үүрэг өгдөг.
- Дэмжлэг авахын тулд ЖДШ$^{+}$-ний сургалт, арга хэрэгслийг ашиглан чадавхжуулах, байгууллагын бүхий л нэгж, хэсгүүдэд ЖДШ$^{+}$-ний талаар мэдээлэл хүргүүлнэ.
- ЖДШ$^{+}$-г ашиглах тодорхой жишээ өгөхийн тулд ЖДШ$^{+}$-ний “жишиг” санаачилга хэрэгжүүлж болно.
- Амжилт, сайн туршлагыг онцолж, зөрүүтэй байдал, шинэ чиглэлийг тодорхойлохын тулд ахиц амжилтыг тасралтгүй хянаж үнэлнэ.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Баярлалаа.